

Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлүүлсэн өргөдөл, гомдол чөлөөний хүсэлтийг хаасан тухай тайлан мэдээ

Байгууллагын хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд ажилчдын нийгмийн баталгааны асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлын тухай тайлдан мэдээг даргын үүрэг болгосноор мэдээг нэгтгэн боловсруулж өгсөн.

Нийт ажилчдаас нийгмийн асуудал шийдвэрлүүлэхээр

- Оюутан сурагчтай 3 албан хаагч
- Барилга байгууламжид дэмжлэг хүссэн 2 албан хаагч
- Өрх толгойлсон -1 албан хаагч эмэгтэй
- Хөгжлийн бэрхшээлтэй хүхэдтэй -1 албан хаагч
- Сувилалд хэвтэх -3 албан хаагчдын өргөдөл гомдолыг бүртгэж

баримтыг бүрдүүлэн ажилласан. Захиргааны зөвлөлөөр шийдвэрлүүлсэн тухай хурлын тэмдэглэлээр баталгаажуулсан.

“Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд нийт 5 албан хаагчийг байгууллагаас дэмжлэг хүсэлтийг шийдвэрлүүлсэн байна.

1. Боловсролын ажилтан Нэргүймаа магистрт суралцах тэтгэлэг
2. Аймгийн бүртгэл мэдээллийн санч Х.Уянга Докторт суралцах хүсэлт
3. БМС Э.Отгонжаргал нь барилга байшингийн явц 60%-тай хийгдэж дэмжлэг хүссэн хүсэлт
4. Ө.Энхчимэг нь байшин барилга эхлүүлж барилга үргэлжлүүлэн барихад дэмжлэг хүссэн тухай нийт 4 өргөдөл дэмжигдэж шийдвэрлэгдсэн.



Говийн Байгаль, Түүхийн Музейг 2025 оны сүүлийн хагас жилийн байдлаар төлбөртэй 8731 үзэгчид үйлчлүүлж түүнээс санал хүсэлтийн дэвтэрт 1.7% нь өөрийн сэтгэгдлээ бичиж үлдээжээ. Үүнд:

1.НИЙТ 149 ҮЗЭГЧ САНАЛ, СЭТГЭГДЛЭЭ БИЧСЭНЭЭС САНАЛ СЭТГЭГДЛҮҮДИЙГ ДУРДВАЛ:


- Танай хамт олонд аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе
- Барилга байгууламж үнэхээр гоё байна
- Түүхийн өв соёлоо хадгалан үзэгч түмний хүртээл болгож байгаад талархья
- Тайлбарлагч нарт баярлалаа, үндэсний хувцсаар жигдэрсэн нь таалагдлаа
- Найрсаг сайхан хамт олон, эелдэг харьцаатай угтлаа
- Цэвэр цэмцгэр тухтай үйлчлүүллээ



Үзүүлэлт 1. / Санал сэтгэгдэл бичсэн төрлүүд/

Мөн говь нутгийг зорьж ирэхдээ музейгээр зочилсон санал сэтгэгдлээ өөрийн хэлээр манай сэтгэгдлийн дэвтэрт бичиж үлдээхийг хүсдэг. Үүний дагуу 45 жуулчны

өөрийн хэл дээр бичсэн сэтгэгдэл болон Монголчуудын өөрсдийн сэтгэгдлийг доорх үзүүлэлтүүдээс харж болно.



Үзүүлэлт 2. / Санал сэтгэгдлээ өөрийн хэлээр бичсэн улс орны тоо/

Сүүлийн хагас жилд 149 хүн санал хүсэлтийн дэвтэр дээр санал сэтгэгдлээ бичсэн. Үүний 69.7% нь Монголчууд, 30.2% буюу 45 нь жуулчид байна. Гадаадын 5288 үзэгчээс 0.8% сэтгэгдлээ бичсэн.

САНАЛ ХҮСЭЛТ

- ✓ Дэлгэрэнгүй Англи тайлбартай байхаар байна
- ✓ Wifi хангалттай хангаж өгөх
- ✓ Агааржуулалт сайжруулах
- ✓ Олон улсын картаар тооцоо хийдэг байх

Бид үзэгчдээс ирсэн санал, хүсэлтийг сайжруулан, шинэ санаа бүгдийг удирдлагын түвшинд хэлэлцэн цаашид хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажилладаг.